



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/283

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх
тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Мандал-18, 18016 тоот)-т байршилтай иргэн Өвгөн овогтой Жаргал (ЗП:76052201)-ын орон сууцны зориулалттай 300 м.кв (0,03га) газрыг иргэн Бадамгарав овогтой Цэрэнням (ЗЮ:92020204)-г зориулалтаар нь шилжүүлж 12 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 05 дүгээр сарын 28-ний өдрийн А/228 дугаар захирамжийн иргэн Ө.Жаргал-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000712353 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210931